



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
БАЯНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2022 оны 09 сарын 01 өдөр

Дугаар А/75

Баянбулаг

┌ Намрын ногоон өдрүүд үзэсгэлэн ┐  
худалдаа зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар хэсгийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Намрын ногоон өдрүүд үзэсгэлэн худалдааг 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр зохион байгуулсугай.

2. Намрын ногоон өдрүүд үзэсгэлэн худалдаа зохион байгуулах удирдамжийг хавсралтаар баталсугай.

3. Үзэсгэлэн худалдаа зохион байгуулахтай холбоотой гарах 1 200 000 (Нэг сая хоёр зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү албаны дарга, нягтлан бодогч нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Н. ГАНСҮХ

642201079

2022 on zahiramj

Баянцагаан сумын Засаг даргын ..... оны 09 сарын  
01 өдрийн ..... дугаар захирамжийн хавсралт



НАМРЫН НОГООН ӨДРҮҮД ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДАА  
ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

**Зорилго:** Орон нутгийн хөрсөнд ургасан экологийн цэвэр түүхий эд, бүтээгдэхүүнийг сурталчилах, үнэлэмжийг нэмэгдүүлэх, өрхийн үйлдвэрлэлийг хөгжүүлэн зах зээлийн орчинг бүрдүүлж, малын ашиг шимийн үзүүлэлтийг тогтоож нэг малаас авах ашиг шимийн хэмжээг нэмэгдүүлэхэд оршино.

**Хугацаа:** 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр зохион байгуулагдана.

**Хамрах хүрээ:** Баянцагаан сумд үйл ажиллагаа явуулж буй албан байгууллага, аж ахуйн нэгж иргэд, малчид нээлттэй оролцоно.

**Үзэсгэлэнгийн төрөл**

1. Газар тариалангийн бүтээгдэхүүн
2. Шилдэг хээлтүүлэгч (бух, хуц, ухна)
3. Шилдэг хээлтэгч (үнээ, эм хонь, хурга)
4. Гар урлал
5. Хүнсний бүтээгдэхүүн, сүү цагаан идээ

**Шалгаруулалт:** Шилдэг хээлтүүлэгч хуцыг нас гүйцсэн, төлгөн, хурган гэсэн гурван (үүлдэрлэг байдал, амьдын жингээр) ангиллаар шалгаруулна.

Шилдэг хээлтэгч үнээг үүлдэрлэг байдал, сүүний гарцыг харьцуулна.

Шилдэг хээлтэгч эм хонины амьдын жинг үзнэ (5 хонины дунджаар).

Хургыг хүйс харгалзахгүй амьдын жинг үзнэ (3 хурганы дунджаар).

Бух (үүлдэрлэг байдал, амьдын жингээр) шалгаруулна.

Ухныг (үүлдэрлэг байдал, ноолуурын микроноор) шалгаруулна.

**Шагнал урамшуулал:** Дээрх төрлүүдэд тус бүр эхний 3 байр шалгаруулж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

**1. Газар тариалангийн бүтээгдэхүүн**

- 1-р байр өргөмжлөл 50000 төгрөг
- 2-р байр өргөмжлөл 30000 төгрөг
- 3-р байр өргөмжлөл 20000 төгрөг

**2. Шилдэг хээлтүүлэгч мал төрөл тус бүрээр**

- 1-р байр өргөмжлөл 50000 төгрөг
- 2-р байр өргөмжлөл 30000 төгрөг
- 3-р байр өргөмжлөл 20000 төгрөг

**3. Шилдэг хээлтэгч мал төрөл тус бүрээр**

- 1-р байр өргөмжлөл 50000 төгрөг
- 2-р байр өргөмжлөл 30000 төгрөг
- 3-р байр өргөмжлөл 20000 төгрөг

**4. Гар урлал**

- 1-р байр өргөмжлөл 50000 төгрөг
- 2-р байр өргөмжлөл 30000 төгрөг
- 3-р байр өргөмжлөл 20000 төгрөг

**5. Хүнсний бүтээгдэхүүн, сүү цагаан идээ**

- 1-р байр өргөмжлөл 50000 төгрөг
- 2-р байр өргөмжлөл 30000 төгрөг
- 3-р байр өргөмжлөл 20000 төгрөг

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН  
ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАСАГ